



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: СЭА-2022/257/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас: 7036-3040      Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 7036-3036      Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>
	Аудитор: Т.Мөнхзул
	Утас: 7036-2442      Цахим хаяг: <a href="mailto:Munkhzult@audit.gov.com">Munkhzult@audit.gov.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

–	
1. Аудитын санал, дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4. Материаллаг байдал	
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	
3.8. Аудитын гол асуудал	18
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЕГ	Татварын ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.23 № СЭА-2022/257-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА  
Б.МӨНХТӨР ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 12/АБ 90463  
САА-2022/257-НА-ЕТД-ЗУС

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тус байгууллагын 18 албан хаагчийг гэнэтийн ослын даатгалд хамруулах гэрээ байгуулан даатгалын хураамжийн зардлаас 90.0 мянган төгрөгийг шилжүүлсэн,
- Тайлант оны үйл ажиллагаанд 385,129,8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 382,483.8 мянган төгрөгийг зарцуулан, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувиар буюу 0.7 хувиар хэмнэсэн байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх "....батлагдсан төсөөт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" 2.0803-Даатгалын үйлчилгээ-Хуульд заасан заавал даатгалын төрлүүдэд байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг даатгуулж.." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.6 "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан, " 4.2.1.11-д "Хууль тогтоомж гэрээ, хэлэлцэл зөрчсөн..." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, Засгийн газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчлүүдийг давтан гаргахгүй ажиллаж,

018040034

биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

- Цаашид холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхтөр, нягтлан бодогч Б.Түвшинжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Т.МӨНХЗУЛ

## 2. Аудит, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>46,567,807.39</b>	<b>53,432,371.12</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>0</b>	<b>28</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>4,939,520.00</b>	<b>15,691,554.39</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,939,520.00	0
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>0</b>	<b>15,691,554.39</b>
33510	Байгууллагаас авах авлага	0	15,691,554.39
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>0</b>	<b>7,200,000.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	0	7,200,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>41,628,287.39</b>	<b>30,540,788.73</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>4,948,919.19</b>	<b>4,220,788.73</b>
35110	Тусгай зориулалттай материал	4,948,919.19	4,220,788.73
35300	Бэлэн бүтээгдэхүүн	10,000,000.00	0
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>2,879,368.20</b>	<b>2,520,000.00</b>
35420	Аж ахуйн материал	1,555,368.20	416,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,100,000.00	0
35470	Бусад хангамжийн материал	224,000.00	2,104,000.00
35500	Биологийн хөрөнгө	0	0
35600	Мал амьтад	23,800,000.00	23,800,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>232,896,260.41</b>	<b>308,375,394.67</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>232,896,260.41</b>	<b>308,375,394.67</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>224,478,260.53</b>	<b>302,224,061.35</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	85,789,480.96	116,789,480.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,253,216.16	-18,646,348.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	186,150,000.00	173,150,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-146,850,000.08	-142,341,666.76
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	153,793,272.76	156,693,172.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	-53,215,815.71	-81,964,011.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,881,976.75	26,881,976.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,817,437.99	-15,987,505.97
39214	Бусад үндсэн хөрөнгө	0	108,805,609.93
39215	Хуримтлагдсан элэгдэл	0	-21,156,646.70
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>8,417,999.88</b>	<b>6,151,333.32</b>
39301	Программ хангамж	6,800,000.00	6,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,350,000.12	-5,616,666.68
39303	Бусад биет бус хөрөнгө	4,968,000.00	4,968,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>279,464,067.80</b>	<b>361,807,765.79</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>15,691,582.39</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>15,691,582.39</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>0</b>	<b>15,691,582.39</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0</b>	<b>15,691,582.39</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0	15,691,582.39
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>279,464,067.80</b>	<b>346,116,183.40</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>279,464,067.80</b>	<b>346,116,183.40</b>

**Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	806,717,089.41	806,717,089.41
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-612,679,589.89</b>	<b>-546,027,474.29</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-341,992,891.44	-612,679,589.89
51220	Тайлант үеийн үр дүн	-270,686,698.45	66,652,115.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	85,426,568.28	85,426,568.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>279,464,067.80</b>	<b>361,807,765.79</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>509,672,267.30</b>	<b>535,244,958.63</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>33,164,347.30</b>	<b>109,110,138.63</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>33,164,347.30</b>	<b>109,110,138.63</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	20,000,000.00	109,005,609.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	13,164,347.30	104,528.70
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>476,507,920.00</b>	<b>426,134,820.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>466,568,400.00</b>	<b>416,129,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	466,568,400.00	385,129,800.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	0	31,000,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,939,520.00</b>	<b>10,005,020.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,939,520.00	10,005,020.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	0
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>594,717,841.72</b>	<b>468,592,843.03</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>594,717,841.72</b>	<b>468,592,843.03</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>578,515,208.90</b>	<b>464,360,540.31</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>223,644,299.25</b>	<b>229,821,336.13</b>
210101	Үндсэн цалин	171,648,061.78	184,628,224.10
210102	Нэмэгдэл	44,719,076.81	38,302,112.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,277,160.66	6,891,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,543,781.23</b>	<b>29,792,336.26</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,697,501.37	21,210,682.31
210202	Тэтгэмжийн даатгал	2,238,953.39	2,316,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,796,202.72	1,836,204.89
210204	Ажилгүйдлийн даатгал	437,311.25	402,668.20
210205	Эрүүл мэндийн даатгал	4,373,812.50	4,026,680.86

**Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>12,585,599.23</b>	<b>12,956,163.69</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,444,925.23	1,198,907.69
210302	Түлш, халаалт	9,982,187.00	9,982,186.00
210303	Цэвэр, бохир ус	1,158,487.00	1,775,070.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,139,209.47</b>	<b>41,621,501.06</b>
210401	Бичиг хэрэг	2,258,100.00	3,501,638.70
210402	Тээвэр, шатахуун	18,672,400.00	22,576,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,039,709.47	2,661,779.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	303,000.00	793,984.50
210408	Бараа материал акталсны зардал	866,000.00	12,087,498.66
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,370,700.00</b>	<b>1,671,427.50</b>
210502	Хоол, хүнс	1,370,700.00	1,671,427.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,595,400.00</b>	<b>10,691,200.00</b>
210604	Урсгал засвар	1,595,400.00	10,691,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,602,900.00</b>	<b>8,262,300.00</b>
210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	4,602,900.00	8,262,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>89,225,758.00</b>	<b>42,012,284.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,162,503.00	31,883,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,600.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	6,000,000.00	5,769,206.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	288,000.00	333,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	3,600,000.00
210807	Газрын төлбөр	1,655.00	294,178.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>192,807,561.72</b>	<b>87,531,991.67</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,060,467.30	20,305,616.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,560,000.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,187,094.42	67,226,375.67
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,202,632.82</b>	<b>4,232,302.72</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>14,928,000.00</b>	<b>1,586,400.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,248,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,680,000.00	1,586,400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,274,632.82</b>	<b>2,645,902.72</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,274,632.82	2,645,902.72
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-85,045,574.42</b>	<b>66,652,115.60</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>185,641,124.03</b>	<b>0</b>

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	185,641,124.03	0
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-270,686,698.45</b>	<b>66,652,115.60</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

К о д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	806,717,089.41	142,161,139.21	(398,727,462.37)	550,150,766.25
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	(56,734,570.93)	56,734,570.93
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	806,717,089.41	142,161,139.21	341,992,891.44	606,885,337.18
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	(56,734,570.93)	0	(56,734,570.93)
9	Тайлант үеийн үр дүн	0	0	(270,686,698.45)	(270,686,698.45)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	806,717,089.41	85,426,568.28	(612,679,589.89)	279,464,067.80
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	806,717,089.41	85,426,568.28	(612,679,589.89)	279,464,067.80
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	806,717,089.41	85,426,568.28	(612,679,589.89)	279,464,067.80
19	Тайлант үеийн үр дүн	0	0	66,652,115.60	66,652,115.60
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	806,717,089.41	85,426,568.28	(546,027,474.29)	346,116,183.40

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>476,507,920.00</b>	<b>400,074,368.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0</b>	<b>28</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0</b>	<b>28</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0</b>	<b>28</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	28
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>476,507,920.00</b>	<b>400,074,340.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>466,568,400.00</b>	<b>385,129,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	466,568,400.00	385,129,800.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,939,520.00</b>	<b>14,944,540.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,939,520.00	14,944,540.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	0
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>465,857,920.00</b>	<b>397,374,440.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>465,857,920.00</b>	<b>397,374,440.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>444,715,767.18</b>	<b>393,142,137.28</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>223,457,099.25</b>	<b>229,821,336.13</b>
210101	Үндсэн цалин	177,014,229.78	184,628,224.10
210102	Нэмэгдэл	39,165,708.81	38,302,112.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,277,160.66	6,891,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,543,781.23</b>	<b>29,792,336.26</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,697,501.37	21,210,682.31
210202	Тэтгэмжийн даатгал	2,238,953.39	2,316,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,796,202.72	1,836,204.89
210204	Ажилгүйдлийн даатгал	437,311.25	740,546.07
210205	Эрүүл мэндийн даатгал	4,373,812.50	3,688,802.99
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>12,585,599.23</b>	<b>12,956,163.69</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,444,925.23	1,198,907.69
210302	Түлш, халаалт	9,982,187.00	9,982,186.00
210303	Цэвэр, бохир ус	1,158,487.00	1,775,070.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,766,109.47</b>	<b>30,064,977.20</b>
210401	Бичиг хэрэг	1,984,600.00	3,412,110.00
210402	Тээвэр, шатахуун	13,198,400.00	16,096,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,039,709.47	2,661,779.20

**Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,543,400.00	7,894,488.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>279,000.00</b>	<b>0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	279,000.00	0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,076,100.00</b>	<b>12,249,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	376,200.00	0
210604	Урсгал засвар	1,699,900.00	12,249,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,602,900.00</b>	<b>3,706,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,602,900.00	3,706,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>138,959,758.00</b>	<b>60,402,284.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	131,896,503.00	43,073,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,600.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	6,000,000.00	5,769,206.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	288,000.00	333,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	1,655.00	294,178.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,445,420.00</b>	<b>14,149,540.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,945,420.00	14,149,540.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,500,000.00	0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21,142,152.82</b>	<b>4,232,302.72</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>14,928,000.00</b>	<b>1,586,400.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,248,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,680,000.00	1,586,400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>6,214,152.82</b>	<b>2,645,902.72</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,274,632.82	2,645,902.72
213304	Хөрөнгийн	0	0
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,939,520.00	0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>10,650,000.00</b>	<b>2,699,928.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>10,650,000.00</b>	<b>2,699,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,650,000.00</b>	<b>2,699,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>10,650,000.00</b>	<b>2,699,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,650,000.00	2,699,900.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-10,650,000.00</b>	<b>-2,699,900.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0</b>	<b>28</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	28

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>385,129,800.00</b>	<b>382,483,897.28</b>	<b>-2,645,902.72</b>	99.3
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>385,129,800.00</b>	<b>382,483,897.28</b>	<b>-2,645,902.72</b>	99.3
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>384,543,400.00</b>	<b>381,897,497.28</b>	<b>-2,645,902.72</b>	99.3
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>229,946,900.00</b>	<b>229,821,336.13</b>	<b>-125,563.87</b>	99.9
210101	Үндсэн цалин	182,018,400.00	184,628,224.10	2,609,824.10	101.4
210102	Нэмэгдэл	40,008,500.00	38,302,112.03	-1,706,387.97	95.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,920,000.00	6,891,000.00	-1,029,000.00	87.0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>31,042,800.00</b>	<b>29,792,336.26</b>	<b>-1,250,463.74</b>	96.0
210201	Тэтгэврийн даатгал	21,844,900.00	21,210,682.31	-634,217.69	97.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,316,100.00	2,316,100.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,839,600.00	1,836,204.89	-3,395.11	99.8
210204	Ажилгүйдлийн даатгал	741,500.00	740,546.07	-953.93	99.9
210205	Эрүүл мэндийн даатгал	4,300,700.00	3,688,802.99	-611,897.01	85.8
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,562,300.00</b>	<b>12,956,163.69</b>	<b>-606,136.31</b>	95.5
210301	Гэрэл, цахилгаан	1,285,700.00	1,198,907.69	-86,792.31	93.2
210302	Түлш, халаалт	10,247,000.00	9,982,186.00	-264,814.00	97.4
210303	Цэвэр, бохир ус	2,029,600.00	1,775,070.00	-254,530.00	87.5
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,376,000.00</b>	<b>30,064,977.20</b>	<b>-311,022.80</b>	99.0
210401	Бичиг хэрэг	3,432,600.00	3,412,110.00	-20,490.00	99.4
210402	Тээвэр, шатахуун	16,153,200.00	16,096,600.00	-56,600.00	99.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,865,500.00	2,661,779.20	-203,720.80	92.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,924,700.00	7,894,488.00	-30,212.00	99.6
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,199,900.00</b>	<b>14,949,100.00</b>	<b>-250,800.00</b>	98.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,699,900.00	2,699,900.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	12,500,000.00	12,249,200.00	-250,800.00	98.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,711,000.00</b>	<b>3,706,300.00</b>	<b>-4,700.00</b>	99.9
210702	Дотоод албан томилолт	3,711,000.00	3,706,300.00	-4,700.00	99.9
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>60,499,500.00</b>	<b>60,402,284.00</b>	<b>-97,216.00</b>	99.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,120,800.00	43,073,400.00	-47,400.00	99.9
210803	Даатгалын үйлчилгээ	5,769,300.00	5,769,206.00	-94.00	100.0

**Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210804	Тээврийн хэрэгслийн татвар	333,500.00	333,500.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.00	132,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	10,800,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	343,900.00	294,178.00	-49,722.00	85.5
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>205,000.00</b>	<b>205,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	205,000.00	205,000.00	0.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>586,400.00</b>	<b>586,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>586,400.00</b>	<b>586,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	586,400.00	586,400.00	0.00	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>385,129,800.00</b>	<b>382,483,897.28</b>	<b>2,645,902.72</b>	<b>-</b> 99.3
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>385,129,800.00</b>	<b>382,483,897.28</b>	<b>2,645,902.72</b>	<b>-</b> 99.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	385,129,800.00	382,483,897.28	2,645,902.72	- 99.3
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>21</b>	<b>21</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16	12	-4.00	75.0
620003	Үйлчлэх ажилтан	4	8	4.00	200.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>21</b>	<b>21</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	13	13	0.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>14,944,540.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>14,944,540.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>13,944,540.00</b>
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>13,944,540.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	13,944,540.00
213	<b>Урсгал шилжүүлэг</b>	-	<b>1,000,000.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,000,000.00
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>14,944,540.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>14,994,540.00</b>
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	14,944.540

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /цаашид Хүнс, хөдөө аж ахуйн газар гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт болон төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байхтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүнс, газар тариалан, мал аж ахуй, хөнгөн, жижиг дунд үйлдвэр, салбарын бодлогыг оновчтой тодорхойлж, хэрэгжүүлж эрчимжсэн газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүн амыг эрүүл аюулгүй чанартай хүнсээр хангах”-д оршино.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мал аж ахуй, мал эмнэлэг, газар тариалан, хүнс, хөнгөн, жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ, хоршооны тогтвортой хөгжлийг хангах, эрчимжүүлэх, дотоод худалдааны бодлогыг боловсруулах, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох,
- Хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, усан хангамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах зохицуулах,
- Тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, эрчимжүүлэх, таримал ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх, тариалангийн эдэлбэр

- Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит газрыг эргэлтэд оруулах, хөрсний үржил шимийг сайжруулах, хамгаалах, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Байгалийн гэнэтийн аюул, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах,
  - Салбарын үйлдвэрлэлд шинэ, дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, нутагшуулах, техникийн шинэчлэлийг хийх,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагаанд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудит хийгдээгүй байна

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит зардлыг бодитоор харуулдаг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 594,717.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,920.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 6,690.5 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 82,343,7 мянган төгрөгөөр буюу 29.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	0,028.0	0,028.0
Авлага	4,939.5	15,691.6	10,752.1
Урьдчилгаа		7,200.0	7,200.0
Бараа материал	41,628.3	30,540.8	(11,087.5)
Үндсэн хөрөнгө	232,896.3	308,375.4	75,479.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>279,464.1</b>	<b>361,807.8</b>	<b>82,343.7</b>
Өр төлбөр	-	15,691.6	15,691.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	279,464.1	346,116.2	66,652.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>279,464,1</b>	<b>361,807.8</b>	<b>82,343.7</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 28 төгрөг нь жижиг мөнгөн сангийн дансанд үлдсэн үлдэгдэл болно.

Авлага дансны үлдэгдэл 10,752.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Хөдөө аж ахуйг дэмжих сангаас шилжиж ирсэн төмс, ногооны 59,636.3 мянган төгрөгийн үрийг сумдын аж ахуйн нэгж, иргэдэд хөнгөлөлттэй үнээр олгосон боловч зарим сумдын иргэн, аж нэгжийн төлөгдөөгүй үлдэгдлээс шалтгаалсан байна.

Урьдчилж гарсан зардал 7,200.0 мянган төгрөгөөр өссөн нь Хүнс хөдөө аж ахуйн салбарын сүүлийн 10 жилийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээллийг сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга болон төсвийн шууд захирагчид цахим орчинд төсвийн явцтай шууд танилцах боломжоор хангах

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<https://www.open.gov.mn> онлайн программ хангамжийг 2022 оныг дуустал ашиглах үйлчилгээний төлбөрийг "Дата ланд технологи" ХХК-тай хийсэн гэрээний дагуу урьдчилан төлсөнтэй холбоотой болно.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 30,540.8 мянган төгрөг болж 11,087.5 мянган төгрөгөөр буурсан нь нийт 38,179.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 59,636.3 мянган төгрөгийн төмс ногооны үр шилжиж ирсэн, 108,903.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 594,088.2 мянган төгрөг болж 129,705.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2,699.9 мянган төгрөгийн 1 ширхэг зөөврийн компьютер авсан болон ХХААХҮЯ-наас 108,805.6 мянган төгрөгийн 10 ширхэг хүлэмж, 20 ширхэг зөөврийн усан сан шилжиж ирсэн, 31,000.0 мянган төгрөгийн албан конторын их засвараар барилгыг капиталжуулсан, аймгийн ЗДТГ-аас 200.0 мянган төгрөгийн халуун хэмжигчтэй гар ариутгагч үнэ төлбөргүйгээр орлогод бүртгэсэн, аймгийн ИТХ-ын 2020 оны 59 дүгээр тогтоолоор 13,000.0 мянган төгрөгийн үнэтэй Nissan Fuga суудлын автомашиныг бүртгэлээс хассантай холбоотой байна.

Өр төлбөр 15,691.6 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн нэгж, иргэдээс авах авлагыг Хөдөө аж ахуйг дэмжих санд төлөх өглөгөөр бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 346,116.2 мянган төгрөг болж 66,652.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 2,028,207.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 1,700,798.5 мянган төгрөгөөр бууруулж, 327,409.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь цалин, хөлс болон НДШ-ийн зардлыг 92,090.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9,886.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 1,627,0 мянган төгрөгөөр, урсгал засварыг 1,487,750.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 109,445.5 мянган төгрөгөөр бууруулан баталсантай холбоотой байна.

2021 оны 6, 11 дүгээр сард батлагдсан төсөвт өөрчлөлт оруулж, 57,720.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 385,129.8 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 385,129.8 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 385,129.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 382,483.9 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 1,376.1 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 606.1 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 311.0 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 250.8 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 4.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгэлцүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 97.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, тайлант хугацааны эцэст төсөвт 2,645.9 мянган төгрөг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130019401 тоот дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 14,944.5 мянган төгрөг, Шинэ хөдөө төслийн хүрээнд хөнгөлөлттэй үнээр иргэд аж ахуй нэгжид олгосон хүлэмжийн үнийн 53,900.0 мянган төгрөг, хөнгөлөлттэй үнээр олгогдсон төмс ногооны үрийн эргэн төлөлтийн 43,545.9 мянган төгрөг зэрэг нийт 112,390.4 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Үүнээс: Аймгийн Засаг даргын 2021 оны А/135 дугаар захирамжийн дагуу мал сүрэгт үзлэг ангилалт хийх шатахууны зардалд 4,895.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх бүртгэл ангилалтын ажил үйлчилгээний зардалд 3,139.5 мянган төгрөгийг, А/355 дугаар захирамжийн дагуу махны өргөтгөсөн худалдаанд оролцох шатахууны зардалд 4,109.5 мянган төгрөгийг сумдад шилжүүлж, А/37 дугаар захирамжаар шилдэг ахуй үйлчилгээ шалгаруулах тэмцээн зохион байгуулж шагнал, өргөмжлөлийн зардалд 2,800.0 мянган төгрөгийг зарцуулж, хүлэмжийн үнийн 53,900.0 мянган төгрөгийг аймгийн ерөнхий орлогын дансанд, төмс ногооны үрийн эргэн төлөлтийн 43,545.9 мянган төгрөгийг Хөдөө аж ахуйг дэмжих сангийн дансанд тус тус төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

1. ХХААХҮЯ-ны сайдын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А-145 дугаар тушаалаар 108,805.6 мянган төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг хүлэмж, 20 ширхэг зөөврийн усан санг тухайн аймгийн ХХААГ-т хуваарилан, түрээсийн гэрээгээр аж ахуйн нэгж иргэдэд олгохыг үүрэг болгосон байна.

Гэвч дээрх хөрөнгүүдийг аймгийн ХХААГ-аар дамжуулалгүй тухайн тойргоос УИХ-д сонгогдсон Ж.Эрдэнэбат гишүүний бие төлөөлөгчөөр дамжуулан аж ахуйн нэгж иргэдэд тараагдсанаас шалтгаалан тухайн хөрөнгийг хүлээн авсан аж ахуйн нэгж, иргэдтэй түрээсийн гэрээ байгуулаагүй, хөрөнгийг биетээр хүлээн авалгүйгээр зөвхөн ХХААХҮЯ-наас ирүүлсэн зарлагын баримтыг үндэслэн данс бүртгэлд тусгасан нь төсвийн хөрөнгө эзэнгүйдэх, алдагдах эрсдэлтэй байна.

Цаашид ХХААХҮЯ-наас олгож буй хөрөнгийг аймгийн ХХААГ-аар дамжуулан, хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2. ХХААХҮЯ-аас төсвийн жилийн эцэст буюу 2021 оны 11 дугаар сард мэдээлэл технологийн зардлыг үндэслэлгүйгээр 7,200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, төсвийн зохицуулалт хийсэн байна.

Энэ нь төсвийг төсвийн жилийн хугацаанд багтаан зарцуулах цаг хугацааны хязгаарлагдмал байдал үүсгэх, үүнээс шалтгаалан авлага үүсгэх эрсдэлийг үүсгэснээс <https://www.open.gov.mn> онлайн программ хангамжийг дараа онд буюу 2022 оныг дуустал ашиглах үйлчилгээний төлбөрийн зардлын 7,200.0 мянган төгрөгийг “Дата ланд технологи” ХХК-д урьдчилан шилжүүлсэн байна.

Цаашид төсвийн зохицуулалтыг үндэслэлтэй хийж, авлага үүсгэхгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант хугацаанд Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллээс 148 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь тайлант оны үйл ажиллагаанд 385,129.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 382,483.8 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.7 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *".....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах"* гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2019 оны А/60 дугаар тушаалаар "Итгэмжлэл" олгож, Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

## **4. Илрүүлэлт**

Аудитаар нийт 47,644.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 8,584.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 900.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 38,160.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл дутуу боловч төлбөр тооцоог бүрэн барагдуулж санхүүгийн тайланд зардлаар тусгасан ажил гүйлгээний баримтыг бүрдүүлэн 8,584.4 мянган төгрөгөөр залруулж баталгаажуулав. Үүнд:

- Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр хууль эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх 2,040.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, төлбөр тооцоог гүйцэтгэсэн ажил гүйлгээний гэрээ дүгнэсэн акт болон хийсэн ажлын тайланг нөхөн бүрдүүлсэн,
- "Сэлэнгэ шүтээн" ХХК-тай байгуулсан тухайн байгууллагын хийж гүйцэтгэж байгаа ажлуудыг олон нийтэд сурталчлах цахим сэтгүүл бэлтгэх 900.0 мянган төгрөгийн гэрээ дүгнэсэн тайланг нөхөн бүрдүүлсэн,
- Баталгаажсан үүлдэр омгийн малд үзлэг ангилалт хийх 5,444.4 мянган төгрөгийн ажлыг мэргэшсэн мал зүйч Алтанцэцэгээр гүйцэтгүүлж, ажлын хөлсийг шилжүүлсэн боловч ажил гүйцэтгэх гэрээг аж ахуйн нэгжтэй байгуулсан байсныг залруулсан,

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Албан хаагчдын цалингаас суутгасан хамтын сангийн төлбөрийг 200.0 мянган төгрөгөөр илүү шилжүүлснийг нөхөн төлүүлж, залрууллаа.

#### 4.2 Албан шаардлага

Байгууллагын 18 албан хаагчийг гэнэтийн ослын даатгалд хамруулах гэрээ байгуулан даатгалын хураамжийн зардлаас 900.0 мянган төгрөгийг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” 210803-Даатгалын үйлчилгээ-Хуульд заасан заавал даатгуулах даатгалын төрлүүдэд байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг даатгуулж..” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх

#### 4.3 Зөвлөмж

##### 1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд 38,160.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Заглуулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	6	47,644.8	4	8,584.4			1	900.0	1	38,160.4